



**ДУНДГОЛ ТООЦООНЫ ТӨВИЙН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ**

**ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт / Дундгол тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх  
гэрээний нэр:**

**Тендер шалгаруулалт / ТБ/201901195  
гэрээний дугаар:**

**Төсөв: 12,945,063 төгрөг**

**Улаанбаатар хот  
2019 он**

## НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

*Төрийн банк* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Дундгол тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх* тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2019 оны 6-р сарын 14-ний өдрийн 11 цаг 00* минутаас өмнө *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем* ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *тухайн өдрийн 11 цаг 20 минутад* нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем* ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс авна. Утас: 94006266

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p>   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | <p>3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлэс бүрдэнэ:</p> <p class="list-item-l1">(а) Үнийн санал;</p> <p class="list-item-l1">(б) Үнэлгэдсэн үе шатны ажлын хуваарь;</p> <p class="list-item-l1">(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p class="list-item-l1">(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p class="list-item-l1">(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p>  |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.</p> <p>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтаасан гэж үзнэ.</p> <p>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хурамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> |
| <b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | <p>5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>  |
| <b>6. Алдааг залруулах</b>                    | <p>6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <p class="list-item-l1">(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</p> <p class="list-item-l1">(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</p>  |

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн санал баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/.</li> <li>2. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</li> <li>3. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Тодорхойлолтын доод хэсэгт байрлах баркод болон тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаар гаргацтай байх шаардлагатай.</li> <li>4. Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ.</li> <li>5. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 1-р сарын 13-ны 18-р тушаал, 2012 оны 6-р сарын 13-ны 181-р тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу тооцно. Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар заавал гүйцэтгэж ирүүлнэ/</li> <li>6. Ажил хийж гүйцэтгэх календарьчилсан хуваарийг баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>7. Тендерт оролцогч нь “Барилга хот байгуулалтын яам”-ны тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагын “2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижолт”-ын зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. Эсхүл Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 01-р сарын 19-ний 11 дүгээр тушаалаар батлагдсан журмын дээрх заалтуудтай дүйцэх тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>8. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харья Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</li> <li>9. Харья дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>10. Харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлолт авч ирүүлнэ.</li> <li>11. Төрийн банкны зүгээс тухайн тендерт оролцогчийн талаар харилцагч банк, харья татвар, шүүх, нийгмийн даатгалын хэлтэс болон бусад байгууллагад хандаж лавлагаа хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ.</li> <li>12. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>13. Чанарын баталгаат хугацаа 1 жил эсхүл түүнээс дээш байна /Баталсан албан бичиг ирүүлнэ/.</li> </ol>

	<p>14. Баталгаат хугацаанд гарсан доголдлыг өөрийн зардлаар шуурхай засварлах ажлыг хийж гүйцэтгэнэ /Баталсан албан бичиг ирүүлнэ/.</p> <p>15. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлнэ.</p> <p>16. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</p> <p>17. 2018 онд санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй засварын ажил гэрээгээр хийж гүйцэтгэсэн туршлагын мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлнэ. Гэрээ, акт ирүүлнэ. Эсхүл гэрээ болон гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>18. 2018 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан ирүүлнэ /Сангийн яамны И-Баланс цахим системд шивэгдэж баталгаажсан байх/.</p> <p>19. Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2018 он.</p> <p>20. Борлуулалтын орлогын хэмжээ: 2018 оны борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.</p> <p>21. Боловсон хүчний мэдээллийг ирүүлнэ. Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Албан тушаал</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Барилгын инженер</td></tr> <tr> <td>2</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td></tr> <tr> <td>3</td><td>2-аас доошгүй засал чимэглэгч</td></tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> <li>- Инженерийн диплом эсхүл мэргэшсэн инженерийн гэрчилгээ, цахим үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн эх хувиас хуулбарласан хуулбар болон НД8 маягтыг сүүлийн 6 сараар ирүүлнэ.</li> <li>- Бусад ажилчдын мэргэжлийн үнэмлэх, цахим үнэмлэхний эх хувиас хуулбарласан хуулбарыг ирүүлнэ.</li> </ul> <p>22. Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй.</p> <p>23. Тендерийн баримт бичгийг ТОӨЗ 1.1-д заасан дарааллын дагуу эмхтгэж, дугаарлаж ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тендерийн хэл нь Монгол хэл дээр байна.</li> <li>• Гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.</li> <li>• ТШӨХ-т заасан баримт бичгүүдээс аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд татгалзах үндэслэл болно.</li> </ul>	№	Албан тушаал	1	Барилгын инженер	2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	3	2-аас доошгүй засал чимэглэгч
№	Албан тушаал								
1	Барилгын инженер								
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан								
3	2-аас доошгүй засал чимэглэгч								
ТОӨЗ 2.1	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b></p> <p><b>2019 оны 6-р сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д цахим хэлбэрээр хүлээн авна.</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн цагаар тоологдох, Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ, нэг файлын хэмжээ зэрэг нь хязгаарлагдмал байдаг зэргийг анхаарна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах,</p>								

	нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.
<b>ТОӨЗ 2.1</b>	<p><b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b>  <b>Байгууллагын хаяг:</b>  <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө.</i></p> <p><b>Огноо:</b> 2019 оны 6-р сарын 14-ний өдөр.</p> <p><b>Цаг:</b>  <i>11 цаг 20 минут</i></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>

# Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1. Ерөнхий шаардлага

Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдех хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм 1-р хэсэг, 2-р хэсэг “Ерөнхий шаардлага БНБД 12.03.04, БНБД 12.04.06 –ийг дагаж мөрдөн ажиллана.

Ажилтануудын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ба ажилтанууд хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангагдсан байна. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрм, стандартыг мөрдөж ажиллаагүйгээс гарах эрсдлийг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.

Барилгын засварын ажлын явцад гарсан хог хаягдлыг зөөвөрлөн, төвлөрсөн хогийн цэгт хаяна. Гүйцэтгэгч нь ашиглагч болон захиалагч захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялан ажиллана. Ажлын тоо хэмжээнд заасаны дагуу ажлыг гүйцэтгэн үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлэн фото зургаар баталгаажуулан акт үйлдсэний дараа дараагийн ажил үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.

Заслын ажилд хэрэглэгдэх замаск, эмульс зэрэг материалууд нь итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээгээр баталгаажсан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх ёстой. Мөн ажилд хэрэглэх элс, хайрга, цемент зэрэг түүхий эд материалууд нь итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан ашиглахад хүлээн зөвшөөрөгдсөн түүхий эд материалууд байна.

Ажилд хэрэглэгдэх аливаа материалуудыг барилгын талбайд их хэмжээгээр татахаас өмнө дээжийг захиалагчид үзүүлж зөвшилцөх зарчим баримталж ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй буюу буруу чанаргүй материал авчирч ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлыг гүйцэтгэгч хариуцна. Заслын ажил БНБД 31-10-05-г хангасан байна.

Ажил эхлэхээс өмнө ажил гүйцэтгэх хугацааны график үргэлжлэх хугацаа, ажиллах хүчиний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Дундгол тооцооны төвийн Захиралын өрөө, барьерийн хэсгийн паркетан шал солих, үүдний өрөө, дээврийн засварын ажлууд хийгдэнэ.

## 2. Дотор заслын ажил

Захирлын өрөө, үүдний өрөөнүүдийн хана, цонхны амалгааны хуучин будгийг ховхолж хуулан хананд тэгшилгээ замаск хийнэ. Ханыг батлагдсан В1661 гэсэн кодтой угаадаг лактай эмульсээр эмульсдэнэ. Ханын эмульсэнд тохирох замаск, зүлгүүр (#120-#180) байна. MNS5526:2005 стандартын шаардлага хангасан замаскийг сонгож хэрэглэх уедээ сайн шалгаж үзсэний үндсэн дээр эмульс, тосон будагны замаскыг сольж хэрэглэхгүй байх. Эмульсэн будаг нь MNS 5252:2003 стандартын шаардлага хангасан байна. Экстра колор В1661 гэсэн кодтой угаадаг лактай эмульсээр будна. Үүдний өрөөний таазыг эмульсэн будгаар будна.

Заслын ажил гүйцэтгэхдээ эргэн тойрондоо юм дэвсэх болон бусад шаардлагатай хамгаалалтын арга хэмжээнүүдийг авах.

## 3. Дээврийн засварын ажил

Үндсэн барилгын дээврийн хайлмал дээврийг буулган дээвэр дээр 15мм-н цементэн тэгшилгээ хийж 1 үе наамал уур тусгаарлагч наана. Дараа нь чулуугүй, чулуутай хар цаасаар 2 үе наана. Барилгын гадна талд ус зайлзуулах хоолойг голмөн төмрөөр хийж угсарна.

Дээврийн ажил БНБД 31-07-05 “өрөнхий ойлголт” зэрэг стандарт, норм дурмийг хангаж ажиллана.

#### **4. Ажилд хэрэглэгдэх материалд тавих шаардлага**

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байх. (БНБД, стандартад нийцсэн байна.)

Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байна.

Чанарын шинжилгээний бичигтэй байна. Материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтэй технологи, хандлагыг бүрэн хангасан байна.

Барилгын ажилд хэрэглэгдэх элс, хайрга, цемент зэрэг түүхий эд материалууд нь итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан, хүлээн зөвшөөрөгдсөн түүхий эд материалууд байна. Орон нутгаас элс хайрга зэрэг барилгын материал авч хэрэглэх тохиолдолд заавал лабораториор шинжлүүлж орцын нормыг тодорхойлуулсан байна.

Шаардлага хангасан тухай шинжилгээний бичигтүй түүхий эд, материалыг барилгын ажилд хэрэглүүлэхгүй болно.

#### **5. Бусад шаардлага:**

Засварын ажлын материалыг өөрчлөх тохиолдолд захиалагч байгууллагад бичгээр хүсэлт гаргана. Хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор албан бичгээр хариу ирүүлээгүй тохиолдолд төсөвт тусгасан материалыар гүйцэтгэнэ.

Техникийн тодорхойлолтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засварын ажлыг тодорхой хугацаагаар зогсоо хүртэл арга хэмжээ авах болно.


Үнийн саналд зардлуудыг тооцохдоо ЗТБХБСайдын 2012 оны 181-р тушаал барилгын төсөв зохиох заавар БНБД 81-95-12 –г мөрдлөгө болгоно.

Авто тээврийн зардлыг ЗТАЖЯ-ны сайдын 2008 оны 09 сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаа батлагдсан жишиг тарифаар тооцно.

#### **6. Ажлын тоо хэмжээ**

Үнийн саналаа ирүүлэхээс өмнө ажлыг газар дээр нь очин танилцаж, хийгдэх ажлуудыг хэмжсэн байх шаардлагатай. Ажлын төсөвт өртгийг тооцохдоо ажлын тоо хэмжээний жагсаалтанд өгөгдсөн хэмжээгээр тооцох ба техникийн тодорхойлолтод хийгдэхээр заагдсан боловч ажлын тоо хэмжээний жагсаалтанд тусгагдаагүй орхигдсон ажил, газар дээр нь очиж үзэхэд засварын ажлыг гүйцэтгэхд заавал хийгдэх шаардлагатай хэдий ч ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй ажлууд гарах тохиолдолд тус ажлыг нийт төсөвт өртөгтөө тооцож ирүүлэх ба ингэж ирүүлээгүйгээс орхигдсон ажлыг гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

## Тав. ЗУРАГ



# Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Төрийн банк

Дунд гол тооцооны төв засварын ажил

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

### ЗАХИРЛЫН ӨРӨӨ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	23.28
2	Хананд замаск хийх	м2	23.28
3	Лактай эмульсээр хана будах	м2	23.28
4	Паркетан шалыг задлаж буулгах	м2	23.25
5	Паркетан шал хийх	м2	23.72

### БАРЬЕРИЙН ХЭСЭГ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Паркетан шалыг задлаж буулгах	м2	31.76
2	Паркетан шал хийх	м2	32.4

### ҮҮДНИЙ ӨРӨӨ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай хана, таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	6
2	Хананд замаск хийх	м2	3.64
3	Лактай эмульсээр хана будах	м2	3.64
4	Тааз цагаан өнгийн эмульсээр будах	м2	2.35

### ДЭЭВРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хүйлмал материалан дээвэр буулгах	м2	215
2	Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	215
3	Дээврийн 1 үе наамал уур тусгаарлагч хийх	м2	215
4	Дээврийг 2 үе руберойдоор бүрж давирхайн шаваасан дээр хамгаалалтын хайрган үетэй хийх	м2	215
5	Барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлцуулах хоолойн хамт хийх	м2	264

**Долоо. ЖИШИГ МАЯГТ**  
**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон усгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.  |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | <b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>  | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
|                                     | <b>9.1.</b> Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |
|                                     | <b>9.2.</b> Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.   |

- |  |   |
|--|---|
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b>            | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэл заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.  |
| <b>В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ</b>                               |   |
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>                      | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.  |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b>            | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.   |
| <b>13. Алданги</b>                                     | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.  |
|  | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дун гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.   |
| <b>Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>                               |   |
| <b>14. Ажил дуусгах</b>                                | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.   |
| <b>15. Хүлээж авах</b>                                 | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.  |
| <b>16. Эцсийн тооцоо</b>                               | 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.<br>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.<br>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ.<br>Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана. |
| <b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлагы</b> | 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө  |

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстай төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүтгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх толбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Дундгол тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх”, ТБ/201901191
<b>ГЕН 2.1</b>	<p>Ажил нь: “Дундгол тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх” бусад гэрээтэй холбогдох байдалаас бүрдэнэ.</p> <p>Ажлын талбай нь: Хавсралтанд зааснаар тодорхойлогдсон болно.</p>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: Төрийн банк, Төв байр, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
<b>ГЕН 4.1</b>	<p>Ажил эхлэх өдөр нь: Гэрээнд заасан хугацаагаар</p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээнд заасан хугацаагаар</p>
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>1 жил</b> байна.
<b>ГЕН 13.1</b>	<p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна.</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.</p>

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;

- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :  
**5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]